

УСНЫ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ

“Үр ашигтай менежментийн тогтолцоо ба тэргүүлэх технологи”

Израиль улсад болох мэргэжлийн сургалт-аяллын танилцуулга

Израиль орны түршлага



Израиль нь хуурай, хагас хуурай уур амьсгалтай, гадаргын цэвэр усны нөөц хомс, улс орны усны хэрэгцээг бүрэн хангах байгалийн эх үүсвэр багатай орон юм. Энэ нь усны менежмент, усны түгээлт, усыг цэвэрлэж эргүүлэн ашиглах шилдэг технологи болон менежментийн шийдлийг эрхэм зорилго болгон хэрэгжүүлэхэд хүргэж, улмаар шилдэг түршлага, олон тооны менежментийн шинэ арга хэрэгсэл, үндэсний технологийг бий болгон хөгжүүлсэн байна. Жишээлбэл, тус улс хаягдал усныхаа 80% орчмыг цэвэрлэж газар тариаланд хэрэглэж байгаа түршлага нь дэлхийн хаана ч байхгүй юм

Израиль нь усны менежментийн нээлтүүд, усны нөөцлөлт, түгээлт, боловсруулалт, хөдөө аж ахуйн усны үр ашигтай хэрэглээгээр болон хаягдал усыг эргүүлэн ашиглах, далайн усны давсыг шүүж цэвэршүүлэх талаар дэлхийд тэргүүлдэг.

Энэхүү сургалт аяллын зорилго нь Израйлийн усны нөөцийн менежментийн шилдэг тогтолцоо, тэргүүлэх технологитой танилцахад оршино.

Сургалтын агуулга



Долоо хоногийн хугацаатай энэхүү мэргэжлийн сургалт-аялал нь тус улсын усны менежментийн салбарт гарсан ололт амжилт, түршлагад тулгуурлан явагдана. Сургалт-аялалд оролцогсод дараах мэдлэг, чадварыг эзэмшинэ:

- Усны нөөцийн хамгаалалт, үр ашигтай хэрэглээ, менежмент
- Хотын ус хангамж (чанарын баталгаа, тоолуур, усны төлбөрийн нэхэмжлэх, хэрэглэгчийн үйлчилгээ)
- Компьютерийн тооцоолол (хуваарилалтын технологи)
- Ус нөөцлөх, түгээх
- Хаягдал усыг эргүүлэн ашиглах
- Их хэмжээний усыг давсгүйжүүлэх технологи
- Усны хэрэглээ, алдагдлыг хэмжих тооцох шийдэл
- Усны аюулгүй байдал
- Ус цэвэршүүлэх, ус хангамж (Усны үндэсний болон инженерийн компаниуд)
- ХАА-д усыг үр ашигтай хэрэглэх, хөдөө аж ахуйн хаягдал усыг боловсруулах, эргүүлэн ашиглах шийдэл

- Усны технологийн тэргүүлэгч компаниудтай танилцах болон ажил хэргийн уулзалт хийх
- Инженерийн компаниуд болон гарааны бизнес эрхлэгчидтэй танилцах болон ажил хэргийн уулзалт хийх
- Усны ашиглалтын стандартчилал

Сургалтын хөтөлбөр

Суралцагчид нь танхимын сургалт болон холбогдох байгууллагуудад зочилж шилдэг технологиудтай газар дээр нь танилцах замаар өөрсдийн мэдлэг, туршлагыг баяжуулж, мэргэжлийн хэлхээ холбоог өргөжүүлнэ. Сургалт-аяллын хөтөлбөрт Израйлийн төр засгийн албан тушаалтан, шийдвэр гаргагчид, хувийн компани болон усны салбарын үйлчилгээний байгууллагынхантай хийх уулзалтууд багтана

Хэрэгжиж буй төслүүдтэй газар дээр нь танилцаж, нэвтрүүлэх боломжтой туршлагыг эх үүсвэрээс нь шууд суралцах боломжийг оролцогчдод олгоно

Жич: Энэхүү хөтөлбөр нь оролцогчдын хэрэгцээ шаардлагаас хамааран өөрчлөгдөх боломжтой

Хэн оролцож болох вэ?

Энэхүү мэргэжлийн сургалт-аялал нь усны нөөцийн менежменттэй холбоотой бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид, усны инженерүүд, төлөвлөгчид, усны салбарын төр, олон нийтийн байгууллага, яамдын ажилтан, хот, суурин газрын болон үйлдвэр компаний удирдлага, ус хангамж, цэвэрлэх байгууламжийн мэргэжилтэн, их дээд сургууль, судалгаа шинжилгээний байгууллага, олон нийтийн болон бизнесийн байгууллагын төлөөлөл, сонирхогчдод зориулагдсан болно

Түүх, дурсгалын аялал

Израиль нь жүүд, христос, лалын шашны сүм хийд, дурсгалт газруудаар баялаг орон. Мэргэжлийн сургалт-аялалын үер оролцогчид нь Ирусалем хотын эртний дурсгалт газрууд болон Галилей нуурын эргэн тойрны үзэсгэлэнт байгаль, Сөнөсөн тэнгис зэрэг алдартай газруудаар аялна.

Мэргэжлийн сургалт-аяллын бүрэлдэхүүнд багтах зүйлс:

- Туршлага судлах мэргэжлийн сургалт-аялалууд, мэргэжлийн уулзалтууд
- Нисэх онгоцны буудлаас угтах, үдэх унааны үйлчилгээ
- Орон нутагт зорчих болон дурсгалт газруудад нэвтрэх эрх
- Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчийн үйлчилгээ
- Израйльд байх хугацааны эрүүл мэндийн даатгал
- Өглөө, үдийн хоол
- Зочид буудлын зардал
- Ирусалем болон Назарет хотын аялал

Энэхүү урьдчилсан хөтөлбөр болон сургалт-аялалтай холбоотой нэмэлт мэдээлэл авч, санал хүсэлтээ солилцох бол дараах хаягаар харилцана уу.

Зохион байгуулагч:

Weitz Center for Sustainable Development, Israel
Ногоон гариг-Ногоон ирээдүй ТББ, Улаанбаатар

Холбоо барих:

Монголд: Н.Оюундарь: earthgreen.ngo@gmail.com ; Утас: 95052526

Израйльд: Ms. Adi Dishon: adi@weitz-center.org; Telephone: 972-8-9474111; Cellular: 972-50-4217616